



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/209

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдааны 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөвт байгууллагын төлбөр тооцоог цахимаар хийж эхэлсэнтэй холбоотой сумын Санхүү албаны дарга нар, Нягтлан бодогч нарт санхүүгийн программын сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хийхтэй холбогдуулан сургалтын зардалд 2,940,000 (хоёр сая есөн зуун дөчин мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 07-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Цайны материал	130	12000	1560000
2	Шагнал 1 дүгээр байр	1	500000	500000
3	Шагнал 2 дугаар байр	1	400000	400000
4	Шагнал 3 дугаар байр	1	300000	300000
5	Өргөмжлөл			180000
	Дүн			2940000